

“Б.Буудай” Худалдааны төв – Асуулт, хариултын сан

Төслийн ерөнхий мэдээлэл

1. Төслийн нэр юу вэ?

“Б.Буудай” худалдааны төв.

2. Төслийг ямар компани хэрэгжүүлж байгаа вэ?

Сейкотек ХХК нь өөрийн эзэмшлийн газарт, холбогдох бүх зөвшөөрөл, стандарт шаардлагын дагуу, 100% өөрийн санхүүжилтээр энэхүү төслийг хэрэгжүүлж байна.

3. Барилгын ажил одоогоор ямар шатандаа явж байна вэ?

Барилгын ажил явагдаж байна. Нийт В1-8 давхар барилга одоогоор 7 дугаар давхар хүртэл каркас угсралт, цутгалт, дүүргэлт, дотор засал, лифт урсдаг шат суурилуулалт, цонх, цахилгаан, сангийн ажлууд явагдаж байна.

4. Хэзээ ашиглалтад орох вэ?

2026 оны 4 дүгээр улиралд ашиглалтад орохоор төлөвлөж байна.

5. Барилга хэдэн давхар вэ?

Нийт 8 давхар.

6. Энэ худалдааны төвийн онцлог юу вэ?

Төрөл бүрийн хүнс, махны бөөний болон жижиглэн худалдаа, сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж, нарны панель, цэнэг хураагуур, монгол гэрийн мод, дагалдах хэрэгсэл, бүх төрлийн сэлбэг, шашны эд зүйл, архи, тамхи, модон эдлэл зэрэг малчид болон орон нутгийн иргэдийн хэрэгцээт бараа бүтээгдэхүүн, эрэгтэй, эмэгтэй, хүүхдийн хувцас хэрэгсэл, гэр ахуйн бараа, гоёл чимэглэл, цахилгаан бараа, эмийн сан, эмнэлгийн тоног төхөөрөмж, үсчин, гоо сайхан, хүүхдийн тоглоомын төв, ресторан, coffee shop, bakery, PC тоглоом, караоке, бильярд, спорт бар зэрэг төрөл бүрийн үйлчилгээ нэг дор төвлөрсөн цогц худалдааны төв юм.

Мөн тэмцээн, уралдаан зохион байгуулах, секц, дугуйлан хичээллэх боломжтой 2 хос стандарт спорт заал, дулаан агуулах, 300 автомашины ил ба дулаан авто зогсоолтойгоороо онцлогтой.

Худалдааны чиглэлтэй холбоотой асуултууд

7. Ямар төрлийн бизнесүүд орох боломжтой вэ?

- Бүх төрлийн хүнсний худалдаа

- Мах, ногооны худалдаа
- Жижиглэн болон бөөний худалдаа
- Малчдад зориулсан бараа бүтээгдэхүүн
- Гэр ахуйн бараа
- Эрэгтэй, эмэгтэй бэлэн хувцас
- Хүүхдийн хувцас, хэрэгсэл
- Бэлэг дурсгал
- Гоёл чимэглэл
- Цахилгаан бараа, гар утас, дагалдах хэрэгсэл
- Эмийн сан, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж
- Хүүхдийн тоглоомын төв
- Хоолны газар
- Ресторан, coffee shop, bakery, түргэн хоол, бэлэн зууш, амттан
- Спорт заал /тэмцээн зохион байгуулах, төрөл бүрийн спорт дугуйлан хичээллэх боломжтой стандарт заал 2ш/
- Биллиард
- Спорт бар
- РС тоглоомын төв
- Дулаан агуулах
- Үсчин, гоо сайхан
- Оёдол, хувцас захиалга
- Түлхүүр хувилах үйлчилгээ
- Хэвлэл, эх бэлтгэл
- Дулаан зогсоол
- 300 машины ил зогсоол

8. Малчдад зориулсан тусгай хэсэгтэй юу?

Малчдад зориулсан худалдааны тусгай хэсэг төлөвлөгдсөн бөгөөд малын эмийн сан, монгол гэрийн хэрэгсэл, нарны зай хураагуур, ТВ, хөргөгч, хөлдөөгч, мотоциклын сэлбэг хэрэгсэл зэрэг орон нутгийн иргэд, малчдын хэрэгцээнд нийцсэн төрөл бүрийн бараа бүтээгдэхүүн худалдаалах боломжтой.

9. Хоолны газар болон ресторан ажиллуулах боломжтой юу?

Тус зориулалтын талбай бүрэн түрээслэгдсэн.

10. Спорт заал ямар зориулалттай вэ?

Стандартын шаардлага хангасан 2 спорт заалтай бөгөөд сагсан бөмбөг, волейбол, заалны хөл бөмбөгийн тэмцээн, уралдаан зохион байгуулах боломжтой. Мөн хүүхэд болон насанд

хүрэгчдэд зориулсан төрөл бүрийн спортын секц, дугуйлан хичээллэх нөхцөлөөр бүрэн тоноглогдсон /дэвжээ, матрас болон бусад хэрэгсэлтэй/.

Спорт заалыг түрээслэхгүй.

11. Агуулахын зориулалттай талбай байгаа юу?

Тийм. Агуулахын зориулалттай талбай В1 давхарт төлөвлөгдсөн. Түрээсийн үнийг барилга ашиглалтад орох үед албан ёсоор тогтооно. Худалдан авалт болон түрээсийн гэрээг эхний ээлжинд байгуулсан харилцагчдад тэргүүн ээлжээр санал болгох боломжтой.

12. Хүүхдийн тоглоомын төв ажиллуулах боломжтой юу?

Тийм. Хүүхдийн тоглоомын төв ажиллуулах зориулалттай талбай түрээслэх боломжтой. Одоогоор 900 м² талбайтай, 6 метрийн өндөртэй зориулалтын талбай төлөвлөгдсөн байна. Түрээсийн үнэ 1 м² нь 50,000 төгрөг бөгөөд талбайг дотор засал хийгдээгүй буюу “хараар” хүлээлгэн өгнө. Дотор тохижилт болон тоног төхөөрөмжийг түрээслэгч өөрөө хариуцна.

Худалдах, түрээслэхтэй холбоотой асуултууд

13. Лангуу болон талбайг худалдах уу, түрээслэх үү?

Тийм. Лангуу болон талбайг худалдан авах, мөн түрээслэх сонголттой.

14. Ямар хэмжээтэй талбайнууд байгаа вэ?

Талбайн хэмжээний хувьд олон төрлийн сонголттой. План зурагт үндэслэн өөрийн хэрэгцээ, үйл ажиллагаанд тохируулан талбайг нэгтгэж, хүссэн хэмжээгээрээ сонгох боломжтой. Хамгийн бага талбайн хэмжээ нь 5 м² байна.

15. Нэг м²-ийн үнэ хэд вэ?

м²-ийн үнийг сар бүр шинэчлэн тогтооно. 2026 оны 06 сарын байдлаар:

- 1 дүгээр давхар- 22,200,000 төгрөг /борлуулалт дууссан, түрээсийн талбай байгаа/
- 2 дугаар давхар- 19,200,000 төгрөг /борлуулалт дууссан, түрээсийн талбай байгаа/
- 3 дугаар давхар – 18,200,000 төгрөг /борлуулах болон түрээслэх талбай байгаа/
- 4 дүгээр давхар – 17,200,000 төгрөг /борлуулах болон түрээслэх талбай байгаа/
- 5 дугаар давхар – 16,200,000 төгрөг /борлуулах болон түрээслэх талбай байгаа/
- 6 дугаар давхар – 15,200,000 төгрөг /борлуулах болон түрээслэх талбай байгаа/

16. Түрээсийн үнэ хэд вэ?

Түрээсийн үнийг мөн адил сар бүр шинэчлэн тогтооно. 2026 оны 06 сарын байдлаар 1м²-ийн түрээсийн үнэ:

- 1 дүгээр давхар- 74,000 төгрөг /борлуулалт дууссан, түрээсийн талбай байгаа/
- 2 дугаар давхар- 69,500 төгрөг /борлуулалт дууссан, түрээсийн талбай байгаа/
- 3 дугаар давхар – 65,000 төгрөг /түрээсийн талбай байгаа/
- 4 дүгээр давхар – 60,000 төгрөг /түрээсийн талбай байгаа/
- 5 дугаар давхар – 55,000 төгрөг /түрээсийн талбай байгаа/
- 6 дугаар давхар – 50,000 төгрөг /түрээсийн талбай байгаа/

17. Төлбөрийн нөхцөл /бэлэн төлөлт/, хуваан төлөх нөхцөл?

Төлбөрийн уян хатан нөхцөлтэй бөгөөд худалдан авагч өөрт тохирсон сонголтоор гэрээ байгуулах боломжтой.

Эхний 100 худалдан авагчид үзүүлэх хөнгөлөлттэй нөхцөл					
Давхар	Давхрын үнэлгээ, төлөлтийн нөхцөлүүд				
	Үндсэн үнэ	100% бэлэн төлөлт	70% бэлэн төлөлт 30% бартер	50% бэлэн төлөлт 50% зээл	30% бэлэн төлөлт, 20% ашиглалтад орох үед, 50% зээл
2 давхар	19,200,000	10,700,000	10,700,000	11,200,000	12,200,000
3 давхар	18,200,000	9,200,000	9,200,000	9,700,000	10,200,000
4 давхар	17,200,000	8,700,000	8,700,000	9,200,000	9,700,000
5 давхар	16,200,000	8,200,000	8,200,000	8,700,000	9,200,000
6 давхар	15,200,000	7,700,000	7,700,000	8,200,000	8,700,000

18. Банкны зээлээр авах боломжтой юу? Ямар банктай хамтарч ажиллаж байгаа вэ?

Болно. Гэрээний үнийн дүнгийн 50% хүртэлх төлбөрийг банкны лизингээр төлөх боломжтой.

19. Лизингээр худалдан авах боломжтой юу?

- Гэрээ байгуулах үед 30%, ашиглалтад орох хүртэл 20%, үлдэгдэл 50%-ийг сарын 1%-ийн хүүтэй, 120 хүртэлх сарын хугацаатай лизингийн нөхцөлөөр төлөх боломжтой.
- Гэрээ байгуулах үед 50%, үлдэгдэл 50%-ийг сарын 1%-ийн хүүтэй, 120 хүртэлх сарын хугацаатай лизингийн нөхцөлөөр төлөх боломжтой.
- Гэрээ байгуулах үед 50%, үлдэгдэл 50%-ийг Голомт, Хаан, Худалдаа хөгжил, Төрийн, Хас банкуудын лизингээр авах боломжтой.

20. Түрээсийн гэрээг ямар хугацаагаар байгуулах вэ?

Хамгийн багадаа 6 сарын хугацаатай байгуулна. Үүн дээр нэмээд 1 сарын түрээсийн төлбөрийг барьцаа төлбөр хэлбэрээр төлнө. Ашиглалтад орсны дараа түрээсийн төлбөр нь зах зээлийн үнэд дүйцүүлэн өөрчлөгдөнө. Барилга ашиглалтад орохоос өмнө гэрээ байгуулж буй түрээслэгчдэд одоогийн үнийг 1 жилийн хугацаанд мөрдөнө.

21. Худалдаж авсан талбайн өмчлөх эрх олгогдох уу?

Гэрээний төлбөр бүрэн төлсөн тохиолдолд улсын комисс хүлээн авч гэрчилгээ гарсны дараа худалдан авсан талбайд үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ олгоно.

22. Талбайн зориулалтыг өөрчлөх боломжтой юу?

Төсөл хэрэгжүүлэгч компаниас зөвшөөрөл авч албан ёсоор батлуулсан тохиолдолд боломжтой.

23. Давхар бүрийн үйл ажиллагааны зориулалтын хуваарилалт ямар байгаа вэ?

V1 давхар:

Махны худалдаа, дулаан агуулах, дулаан авто зогсоол

1- давхар:

Coffee shop, Bakery, Бүх төрлийн хүнс /архи тамхи, шингэн хүнс, жимс, нарийн ногоо, хүнсний ногоо, сүү сүүн бүтээгдэхүүн, хагас боловсруулсан махан бүтээгдэхүүн, чихэр, гурилан бүтээгдэхүүн гэх мэт бүх төрлийн хүнс/, жижиглэн болон бөөний худалдаа

2- давхар:

Гоёл чимэглэл, цэцэг, бэлэг дурсгал, үнэртэй ус, арьс арчилгаа, гоо сайхан, нүдний шил, ном, бичиг хэрэг, үсчин, гоо сайхны салон, гар утас, дагалдах хэрэгсэл, гэр ахуй, нэг удаагийн хэрэгсэл, аялалын хэрэгсэл

3- давхар:

Бүх төрлийн эрэгтэй, эмэгтэй бэлэн хувцас, гутал, бөс бараа, оёдол эсгүүр,

4- давхар:

Эрэгтэй эмэгтэй гутал, цүнх, унтлагын хувцас, дотуур хувцас, спорт хувцас хэрэгсэл, цүнх гутал засвар

5- давхар:

Гал тогооны хэрэгсэл, гэр ахуй, цахилгаан бараа, жижиг тавилга хэрэгсэл, сурагчийн дүрэмт хувцас, хүүхдийн хувцас, хэрэгсэл, тоглоом, спорт бараа,

6- давхар:

Цахилгаан бараа, үндэсний үйлдвэрлэлийн бараа бүтээгдэхүүн

7- давхар:

Ресторан, хоолны газар, бильярд, спорт бар, караоке

8- давхар:

Спорт заал /тэмцээн зохион байгуулах, төрөл бүрийн спорт дугуйлан хичээллэх боломжтой стандарт заал 2ш/, хүүхдийн тоглоомын төв

24. Бартер оруулан төлбөр төлөх боломжтой юу? Бартерын хөрөнгийн үнэлгээг хэрхэн хийх вэ?

Тодорхой хэмжээнд оролцуулах боломжтой. Бартерт санал болгож буй хөдлөх ба үл хөдлөх хөрөнгийн мэдээллийг хүлээн авсны дараа саналыг сонсож, удирдлагад хянуулж эргээд хариу мэдэгдэнэ.

25. Бартераар төлбөр төлөхөд бол ямар материал бүрдүүлэх вэ?

Тухайн хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, холбогдох бичиг баримт, лавлагаа, хөрөнгийн үнэлгээ, эзэмшигчийн бичиг баримт.

26. Талбай сонголт одоогоор хэр их үлдсэн байгаа вэ?

Давхар бүрийн план зураг дээрээс харах боломжтой.

27. Захиалга өгөхийн тулд ямар материал бүрдүүлэх вэ?

Хувь хүн бол иргэний үнэмлэх, Байгууллага бол байгууллагын гэрчилгээтэй ирж гэрээ байгуулна.

28. Байгууллагын нэр дээр авах боломжтой юу?

Боломжтой.

29. Хувь хүн болон байгууллагад санал болгох үнэ ялгаатай юу?

Ялгаагүй.

Барилгын болон дэд бүтцийн асуултууд

30. Автомашины зогсоолтой юу?

300 авто машины ил зогсоол болон дулаан зогсоолтой.

31. Ачаа буулгах тусгай хэсэгтэй юу?

Зориулалтын ачааны машин ачаагаа буулгах тавцан, ачааны хаалга, давхар бүрт хүрэх ачааны лифттэй.

32. Лифттэй юу?

Давхар бүрт зогсох тус бүр нь 20 хүний багтаамжтай хүн болон ачааны нийт 4 лифттэй, 1-6 давхарт зорчигчийн 12 урсдаг шаттай.

33. Ачааны лифттэй юу?

Давхар бүрт зогсох 2 лифт байгаа.

34. Галын аюулгүй байдлын стандарт хангах уу?

Барилгад ашиглаж буй бүх материал галын аюулгүй байдлын стандарт шаардлагад нийцсэн, гал дэмждэггүй материалаар баригдаж байгаа. Давхар бүрт галын бороожуулах системтэй, дулаан мэдрэгч камертай.

35. Камерын хяналтын системтэй юу?

Гадна ба дотор камерын хяналтын системтэй.

36. 24 цагийн хамгаалалттай юу?

24 цагийн харуул, хамгаалалттай.

37. Агааржуулалт болон халаалтын систем ямар байх вэ?

Давхар бүртээ тусгай агааржуулалт, хөргөлтийн системтэй, энэ нь аль нэг давхарт гэмтэл гарсан тохиолдолд зөвхөн тухайн давхарт засвар хийх боломжтой давуу талтай. Төвийн халаалтын системтэй холбогдсон.

38. Интернет болон сүлжээний дэд бүтэц шийдэгдсэн үү?

Давхар бүрт Wi-Fi-тай.

39. Цэвэр бохир усны систем ямар байх вэ?

Нэгдсэн цэвэр бохирын холболттой. Мөн саарал усыг дахин ашиглах системтэй.

40. Эрчим хүчний нөөц шийдэлтэй юу?

Эрчим хүчний яаралтай горимд ажиллах цахилгаан үүсгүүртэй. Дээвэр дээрээ сэргээгдэх эрчим хүч, нарны зай хураагууртай.

Байршил болон урсгалтай холбоотой асуултууд

41. Худалдааны төв яг хаана байрлах вэ?

Москва хорооллын замын чанх урд талд, Sunday, Хархорин худалдааны төвөөс баруун тийш 400м зайд төв зам дагуу, автобусны буудлаас 20м зайтай, төв зам дагуу байрлалтай.

42. Нийтийн тээврийн хүртээмж ямар вэ?

Автобусны буудлын яг хажууд байрлалтай. Замын эсрэг талд мөн автобусны буудал, төвийн болон баруун аймгуудын /15 аймаг/ орон нутгийн автобусны терминал /300м/ байрладаг.

43. Өдөрт дунджаар хэдэн хүн үйлчлүүлэх тооцоотой вэ?

Аймаг, сум, албан байгууллага, бүх үеийн төгсөгчдийн 5 төрөлт спортын арга хэмжээ зохион байгуулах боломжтой бөгөөд нэг удаагийн арга хэмжээнд 500-1500 хүн спорт заалаар үйлчлүүлнэ. Энэ нь худалдааны төвийн маркетинг болон үйлчлүүлэгчдийн урсгал

нэмэгдүүлэхэд давуу тал болно. Мөн хүүхдийн тоглоомын төв, esport төв зэрэг нь үйлчлүүлэгчдэд нэг дороос олон төрлийн үйлчилгээ авах боломжийг бүрдүүлж байгаа.

44. Ойролцоо ямар томоохон зах, худалдааны төвүүд байгаа вэ? Үнийн харьцуулалт

- Шинэ драгон терминал нь 200 машины авто зогсоолтой, сарын түрээс 100,000-200,000 төгрөг, худалдах үнэ 1 м2 нь 15-25 сая төгрөгийн хооронд байна.
- Sunday худалдааны төв нь 70-80 машины авто зогсоолтой, сарын түрээс 60,000-110,000 төгрөг, худалдах үнэ 1 м2 нь 13-25 сая төгрөгийн хооронд байна.
- Хар хорин худалдааны төв нь 300 машины авто зогсоолтой, сарын түрээс 55,000-120,000 төгрөг, худалдах үнэ 1 м2 нь 18-25 сая төгрөгийн хооронд байна.

45. Тухайн байршлын давуу тал юу вэ?

Төв зам дагуу байрлалтай, төвийн шугамд холбогдсон, автобусны буудлын яг хажууд, хотын баруун бүсийн хамгийн их хөл хөдөлгөөнтэй, УБ хотын хамгийн их буюу 670,000 хүн амтай дүүрэгт, худалдаа үйлчилгээ явуулахад хамгийн зөв байршилд байрлаж байна.

Ашиглалт, менежменттэй холбоотой асуултууд

46. Ашиглалтын менежментийг хэн хариуцах вэ?

Төсөл хэрэгжүүлэгч компанийн зүгээс ашиглалт менежментийн алба байгуулан ажиллана.

47. Ашиглалтын төлбөр хэд байх вэ?

Ашиглалтын төлбөр бусад худалдааны төвөөс багаар тогтоогдоно. Ашиглалтад орох үед тодорхой болно.

48. Цэвэрлэгээ, хамгаалалт нэгдсэн байдлаар явах уу?

Тийм.

49. Зар сурталчилгааны нэгдсэн бодлого, дотоод маркетинг, эвент зохион байгуулах уу?

Идэвхижүүлэлтийг ашиглалтад орох үед бүх сувгаар явуулна.

50. Ажиллах цагийн хуваарь ямар байх вэ?

Худалдааны хэсэг: 10:00-22:00 цаг

Бусад үйлчилгээний хэсэг: 24 цагаар ажиллана.

51. Түрээслэгч өөрийн интерьер хийх боломжтой юу?

Төсөл хэрэгжүүлэгч компаниас баталсан зургийн дагуу хийнэ.

52. Дуу чимээ, үйл ажиллагааны журамтай юу?

Ашиглалтад орох үед худалдан авагч, түрээслэгч нарт нэгдсэн журмыг тараан өгч, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана. Биеэ даасан объект учир ямар нэгэн хязгаарлалтгүй ажиллах боломжтой.

Хууль, гэрээтэй холбоотой асуултууд

53. Ямар төрлийн гэрээ байгуулах вэ?

Талбай ашиглалтад орох хүртэл Үл хөдлөх эд хөрөнгө ирээдүйд худалдах, худалдан авах урьдчилсан захиалгын гэрээ, Талбай түрээслэх захиалгын гэрээг байгуулна. Талбай ашиглалтад орсны дараа Үл хөдлөх хөрөнгө худалдах худалдан авах гэрээ, Түрээсийн гэрээг шинэчлэн байгуулна.

54. Гэрээ байгуулахад ямар бичиг баримт шаардлагатай вэ?

Иргэний үнэмлэх, байгууллагын гэрчилгээ.

55. НӨАТ шингэсэн үнэ үү?

НӨАТ ороогүй үнэ.

56. Гадаадын иргэн, хуулийн этгээд худалдан авах боломжтой юу?

Боломжтой.

Борлуулалтын ажилтнуудад зориулсан түгээмэл нэмэлт асуултууд

57. Яагаад энэ төслийг сонгох ёстой вэ?

Олон төрлийн худалдаа, үйлчилгээ нэг дор төвлөрүүлсэн, орчин үеийн цогц худалдааны төв бөгөөд бөөний болон жижиглэн худалдааг зэрэг хөгжүүлэх боломжтой.

58. Хөрөнгө оруулалтын давуу тал, ирээдүйн үнэ цэнийн өсөлтийн төлөв ямар вэ?

Худалдааны төвийн байршил, хүн амын нягтаршил, барилгын материалын чанар, орчин үеийн барилгын шийдэл, төвийн дулаан эрчим хүчний систем, давхар бүрийн агааржуулалт, хяналтын систем, 300 авто машины зогсоол зэрэг, бүх төрлийн худалдаа үйлчилгээг нэг дор төвлөрүүлсэн зэрэг давуу талууд нь ирээдүйд худалдааны төвийн үнэ цэнэ өсөх үндсэн нөхцөл болно.

59. Эрт захиалгын давуу тал юу вэ?

Төсөл хэрэгжүүлэгч компаниас баталсан хөнгөлөлт эдэлнэ.

60. Борлуулалт хийх хэдэн нийт хэдэн талбай байгаа вэ?

Худалдааны төвийн 1-6 давхарт нийт 150 лангуу, талбайг борлуулна. Үлдсэн талбай нь түрээсийн талбай байна.

61. Одоогоор хэдэн хувь нь борлуулагдсан байгаа вэ?

Борлуулалт 2026 оны 5 сарын 30-наас албан ёсоор эхэлсэн.

62. Нээлтийн үйл ажиллагаа хийх үү?

Нээлтийн үйл ажиллагаа хийнэ.

63. Анхны түрээслэгчдэд хөнгөлөлт байгаа юу?

Барилга ашиглалтад орох хүртэл хөнгөлөлттэй үнээр захиалга авч байгаа. Мөн бараа хадгалах дулаан агуулахыг тэргүүн ээлжинд түрээслэх боломжтой.

64. Холбоо барих борлуулалтын албаны дугаар?

Утас: 75330404

65. Showroom эсвэл загвар талбай үзүүлэх боломжтой юу?

Барилгын макеттай танилцах боломжтой.

66. Барилгын явцтай танилцах боломжтой юу?

Барилгын талбай руу хамгаалалтын малга өмсч борлуулагчтай хамт нэвтэрнэ.

67. Онлайн захиалга авах уу?

Авахгүй.

68. Сошиал хаягууд байгаа юу?

Facebook page: V.Buudai center/ Буудай төв



V.Buudai center/ Буудай төв

20K followers • 10 following

ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ

Internet Marketing Service

69. Албан ёсны вэбсайт байгаа юу?

www.bbuudai.com